



МОНГОЛ  
УЛАМ  
СОЦИАЛ  
ТАНГАМ  
УЛАМ

ДОРНОД АЙМГИЙН  
БОЛОВСРОЛЫН  
ГАЗАР

# ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2026

МОНГОЛЫН ТҮҮХ Онлайн сорил-4

5 сарын 30 18.00-19.20

1. 1.Палеолитын үед хамаарах он цагийг олно уу?

/1 оноо/

A. 800.000– НТӨ 3000 жил

B. 100.000– 40.000 жил

C. 40.000– 12.000 жил

D. 800.000– 12000 жил

E. 12000– 8.000 жил

2.

2. Монгол нутаг дахь эртний хүмүүс нас барагсдаа амьтан, эд юмс дагалдуулан оршуулдаг болсон нь аль үед холбогдох вэ?

/1 оноо/

A. Неолит

B. Мезолит

C. Дунд палеолит

D. Доод палеолит

E. Дээд палеолит

3.

3. “Дээд палеолитын үеэс хүн ам өсөж, ан гөрөө нь нийт хүн амын хүнсний хэрэгцээг хангах боломжгүй болсон” гэсэн нь юу үүсэх нөхцөл болсон бэ?

/1 оноо/

A. Нүүдлийн иргэншил үүссэн

B. Олзворлох аж ахуй эрчимжсэн

C. Ан гөрөө, загасчлах аж ахуй үүссэн

D. Түүвэрлэх аж ахуй эрчимжсэн

E. Үйлдвэрлэх аж ахуй үүссэн

4.

4. Нүүдэлчдийн түүх, соёлын дурсгал болох хиргисүүр нь түүхийн аль үед холбогдох вэ?

/1 оноо/

A. Палеолитын дээд шат

B. Неолитын үе, энеолитын үе

C. Хүрлийн үе, төмрийн түрүү үе

D. Мезолитын үе, Неолитын эхэн үе

E. Энеолит буюу зэс чулууны үе

5.

5. Нүүдлийн мал аж ахуй бие даан хөгжихтэй зэрэгцэн хөдөлмөрийн багаж зэвсгийн хөгжилд гарсан томоохон ололт юу байсан бэ? /1 оноо/

- A. Нум сумыг хийх арга технологи
- B. Морины тоног хэрэгсэлийг бүтээх арга
- C. Ваар, шаазан урлах арга
- D. Малын арьс, шир, үс ноос боловсруулах арга
- E. Сүү, цагаан идээ боловсруулах арга

6.

6. Нүүдлийн мал аж ахуйн хөгжилд аль нь чухал үүрэг гүйцэтгэсэн бэ? /2 оноо/

- A. Малын арьс, шир, үс ноос боловсруулсан
- B. Худалдаа, арилжааны олз
- C. Ваар, шаазан урласан
- D. Адууг уналганд ашигласан
- E. Сүү, цагаан идээ боловсруулсан

7.

7. “Архангай аймгийн Өгийнуур сумын нутгаас Хүннүгийн үед холбогдох төмөр суурьтай, хүрэл тогоо олдсон” баримтад ямар дүгнэлт хийх вэ? /1 оноо/

- A. Хүннү нарт зэс, хүрэл зэвсгийн үйлдвэрлэл, гар урлалын арга технологи өндөр хөгжсөн
- B. Хүннү нар хоёр өөр шинж чанартай төмөрлөгийг нийлүүлэн гагнах нарийн технологи эзэмшсэн
- C. Хүннү нар төмөрлөг эдлэл хэрэглэх нь түгээмэл байсан
- D. Хүннү нар хүчирхэг, хөгжингүй байсан нь бие даан зэс, хүрэл зэвсэг боловсруулах арга, технологи эзэмшсэн
- E. Хүннү нар Азийн бусад улсуудын адил зэс, хүрэл зэвсгийг боловсруулж сурсан

8.

8. Неолитын үеэс хүмүүс гөрөөчлөн, нутаг сэлгэх нь цөөрч **суурин** хэв маягийн амьдралд шилжсэнийг гэрчлэх, нүх ухаж байгуулсан, өрхөөр нь орж гардаг, модон багана, шалтай газар сууцууд хаанаас олдсон бэ?

/2 оноо/

A. Сэлэнгэ аймгийн Улаан бургас

B. Өвөрхангай аймгийн Мойлтын ам

C. Дундговь аймгийн Ярх уул

D. Баянхонгор аймгийн Нарийн гол

E. Дорнод аймгийн Тамсагбулагийн суурин

9.

9. Сяньби улс мөхсөн гол шалтгаан нь юу вэ?

/1 оноо/

A. Хань улсын олон удаагийн довтлогоо

B. Алтайн Түрэгүүдийн бослого

C. Олон жил үргэлжилсэн ган зуд

D. Хаан ширээний төлөөх тэмцэл

E. Сяньбичууд суурин соёлд автсанаас

10.

10. Сяньбигийн зарим аймгууд Цагаан хэрмийн дотор суурьшиж 304 оноос Хятадад өөрийн улсуудыг байгуулсан байна. Уг оныг зууны тоололд шилжүүлнэ үү

/2 оноо/

A. НТ IV зууны I хагас

B. НТӨ IV зууны I хагас

C. НТ III зууны I хагас

D. НТӨ III зууны II хагас

E. НТ III зууны II хагас

11.

11. “Хятанчууд нь Дунхугийн салбар юм. Тэдний өвөг, Хүннүд цохигдоод, Сяньби ууланд нутаглаж, Сяньбичууд хэмээгдэв” баримт ямар утга санааг илэрхийлж байна вэ?

/2 оноо/

A. Сяньбичууд анх Дунху хэмээн нэрлэгдэж байсныг баталсан

B. Хятанчууд анх Сяньби хэмээн нэрлэгдэж байсныг баталсан

C. Хятаны өвөг дээдэс Шар мөрөнд орчимд нутаглаж байсныг нотолдог

D. Дунху, Сяньби ба Хятанчууд угсаа гарвал нэг болохыг нотолдог

E. Хятаны өвөг дээдэс Ляоси орчимд нутаглаж байсныг нотолдог

12.

12. Уйгар улсад бурхны шашин дэлгэрч байсан ч Уйгарын хаад аль шашныг ивээлдээ авсан бэ?

/1 оноо/

A. Күнзийн сургаал    B. Бөөгийн    C. Манихейн    D. Христийн Несторын    E. Лалын

13.

13. Эртний улсуудын түүхэнд холбогдох археологийн олдвор олдсон газар, олдворуудыг улстай нь зөв харгалзуулна уу? /2 оноо/

- |          |   |
|----------|---|
| 1. Хүннү | a. Архангай аймаг Хотонт сум Хар балгас хотын туурь           |
| 2. Түрэг | b. Архангай аймаг Өндөр-Улаан сумын Гол мод, Ромын шилэн аяга |
| 3. Уйгар | c. Төв аймаг Эрдэнэ сум Тоньюкукын гэрэлт хөшөө               |

A. 1a2b3c    B. 1b2c3a    C. 1a2c3b    D. 1c2b3a    E. 1c2a3c

14.

14. XI-XII зууны Монгол аймгуудаас аль нь Алтан улсын хойд хилийг сэргийлэн хамгаалах үүрэг гүйцэтгэж байсан бэ? /1 оноо/

A. Хонгирад    B. Ойн иргэд    C. Тайчууд    D. Онгуд    E. Татар

15.

15. Монгол аймгууд аж ахуйн хувьд талын малчин, ойн анчин хэмээх хоёр бүлэгт хуваагддаг. Ойн анчин аймгууд ямар хавсрага аж ахуй эрхэлдэг байв? /1 оноо/

- A. Эсгий ширэх, гар урлал эрхэлж ашиг шимийг нь хүртэх
- B. Ан гөрөө, газар тариалан эрхэлж ашиг шимийг нь хүртэх
- C. Үслэг эдлэл болон үнэт чулууны худалдаа эрхэлж ашиг хүртэх
- D. Загас агнуур болон шаазан ваар урлал эрхэлж ашиг хүртэх
- E. Цаа буга, аргаль, сарлаг гаршуулан сүү шимийг нь хүртэх

16. 1 ба 2 жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ?

/2 оноо/

1. Хэрэйд, Найман
2. Монгол, Татар

- A. Эрхлэх аж ахуйн онцлогоор      B. Засаг захиргааны бүтэц  
C. Угсаа гарвалын ялгаагаар      D. Шашин, шүтлэгийн ялгаагаар  
E. Засаглалын хэлбэрээр

17. Чингис хаан суурин оронтой байлдах туршлага хуримтлуулах үүднээс аль улс руу довтолсон бэ?

/1 оноо/

- A. Сүн улс    B. Алтан улс    C. Тангуд улс    D. Хорезм улс    E. Хар Хятан улс

18. Цагадайн улсын нийслэлийг сонгоно уу

/1 оноо/

- A. Тебриз    B. Алмалиг    C. Дайду    D. Сарай    E. Марага

19. Ил хаант улсын газар нутаг өнөөгийн аль бүс нутагт хамаардаг вэ?

/2 оноо/

- A. Төв болон Зүүн хойд Ази      B. Баруун Ази, Зүүн Европ  
C. Орос, Зүүн Европ      D. Баруун Ази, Ойрхи Дорнод      E. Өмнөд Ази

20. Дундад азийн түүхч Абул Гази Бахадур “Монголын эзэнт гүрний тухайд” хэлэхдээ “Иран, Тураны хоорондох бүх улс оронд урьд байгаагүй энх амгалан үе ирэв. Толгой дээрээ сагс алт тавиад дорноос өрнө тийш цор ганцаар аялан явах бүрэн боломжтой ажгуу” хэмээжээ. Уг сурвалжид ямар үйл явдлын тухай өгүүлж байна вэ? /2 оноо/

- A. Ази, Европын хүн ард амар тайван, аж төрж байсан тухай  
B. Монголын эзэнт гүрний нэгдсэн захиргаанд орсоноор энх тайван тогтсон тухай  
C. Иран болон Турины хооронд худалдаа арилжаа цэцэглэн хөгжиж байсан тухай  
D. Монголын эзэнт гүрэн дорноос өрнө тийш асар удам нутгийг эрхшээж байсан тухай  
E. Дайн самуу, дээрэм тонуулгүй амар тайван болсон тухай

21. XV зууны эхэн үеэс Монголын улс төрийн нэгдмэл байдал сулран доройтож, зүүн, баруун Монгол хэмээн хуваагдан тэмцэлдэх болсны дотоод шалтгааныг олно уу? /1 оноо/  
A. Мянгатын тогтолцоонд шилжсэн үйл явдал болсон  
B. Шарын шашин дэлгэрсэн үйл явдал болсон  
C. Мин улсын хагалган бутаргах бодлого явагдсан  
D. Ноёдын бие даах эрмэлзлэл ихэссэн  
E. Эзлэгдсэн орнуудын бослого тэмцэл гарсан
22. 1388-1400 оны хооронд Монголд таван хаан суусан нь бүгд цаг бусаар хорвоог орхисон байна. Дээрх баримтаас улс төрийн хямрал гүнзгийрсэн шалтгааныг олно уу /1 оноо/  
A. Ноёдын бие даах эрмэлзлэл ихэссэн  
B. Шарын шашин дэлгэрсэний сөрөг нөлөөлөл байсан  
C. Чадварлаг удирдагч төрөн гарахгүй байсан  
D. Эзэн, харьяатын ёс бэхжсэн  
E. Эзлэгдсэн орнуудын бослого тэмцэл болсон
23. Мин улсын Ин Зүн хааныг олзлон, Мин улсад улс төрийн шахалт үзүүлэн түүнийг буцаан өгснөөр өмнө зүгт түр намжмал байдлыг хэн бий болгосон бэ? /1 оноо/  
A. Түмэн засагт  
B. Эсэн тайш  
C. Батмөнх даян хаан  
D. Түмэдийн Алтан хан  
E. Лигдэн
24. Батмөнх даян хаанаас Арын 7 отгийг хэн өвлөн авсан бэ? /1 оноо/  
A. Гэрсэнз B. Алчуболд C. Ашихай D. Барсболд E. Төрболд
25. 1368 онд Тогоонтөмөр хааны Юань гүрэн унаж аль улс Хятадад ноёрхох болсон бэ? /1 оноо/  
A. Дундад Иргэн улс B. Манж Чин улс C. Хятад улс D. Мин улс E. Чусон улс

26.

26. Монголд бурхны шашин дэлгэрэхэд нөлөөлсөн гадаад хүчин зүйлийг олно уу /2 оноо/  
A. Бөөгийн хойлголох ёсыг халж хүн нас барахад амьтаны амь таслахыг хориглосон нь олны сэтгэлд нийцэв  
B. Улсаас лам нарын эрх, дархыг хуульчлан баталж, дэмжих бодлого явуулсан  
C. Бурхны шашны шар, улааны урсгалууд өөрсдийн нөлөөг дэлгэрүүлэхээр өрсөлдөж байсан  
D. Шашинг нэвтрүүлэхийн тулд улсаас эдийн засгийн дэмжлэг үзүүлсэн  
E. Монголын эрх баригчид ард олныг оюун санааны хувьд нэгтгэх зорилготой байсан

27.

27. Дараах шашин, соёлын зүтгэлтнүүдээс “Тод үсэг”-ийг хэн зохиосон бэ? /1 оноо/  
A. Манзушир хутагт  
B. Зая бандида Намхайжамц  
C. Нэйж Тойн  
D. Зая бандида Лувсанпэрэнлэй  
E. Майдар хутагт

28.

28. Бурхны шашнаар дамжин дорнын соёлын нөлөө Монголд нэвтэрсэн баримт аль вэ? /2 оноо/  
A. Хүн нас барвал чинээ чинээгээр тэмээ, морийг алж, хойлголон оршуулдаг байв  
B. Монголчууд үр хүүхдүүддээ гэрийн сургуулиар боловсрол олгож байв  
C. Монголын дүрслэх урлагт “цутгуурын урлаг” гэдэг төрөл шинээр бий болов  
D. Хаад ноёд асар том гэр тэрэг хэрэглэж байв  
E. Монгол ноёд хан, тайш, жинон зэрэг цолыг хэрэглэж байв

29.

29. XVII зуунд Халимагаас Зүүнгар руу буцах нүүдэл хэдэн удаа болсон бэ? /1 оноо/  
A. 6 удаа  
B. 4 удаа  
C. 1 удаа  
D. 7 удаа  
E. 5 удаа

30. 1689 оны Манж-Оросын Нэрчүгийн гэрээний гол агуулга аль вэ? /1 оноо/  
A. Байгаль нуурын зүүн талын Баргужин шивээг мэдэлдээ авах тохиролцоо  
B. Буриад Монголчууд Орос улсын мэдэлд бүрэн орсон  
C. Байгал нуурын баруун биед Эрхүү өвөлжөөг байгуулах тохиролцоо  
D. Орос улс Эрхүү, Түнхэний шивээ орчмын нутгийг харьяандаа оруулсан  
E. Үд шивээг байгуулж, бэхжүүлэх тохиролцоо

31. 1688 оны “Халх – Зүүнгар”-ын дайн ямар үр дүнгээр дууссан бэ? /1 оноо/  
A. Галдан хаан Халхыг харьяат ардын хамт бүхэлд нь эзлэн авсан  
B. Галдан хаан 1690 онд Улаанбутанд ялагдсан  
C. Галдан хаан Тэрэлжийн зуун мод хэмээх газар бут цохигдсон  
D. Халхын ноёд ялагдаж Оросын нутагт буруулан орсон  
E. Халхын ноёд ялагдаж Өвөр Монгол руу буруулан одсон

32. 1756-1758 оны Халх Монголд гарсан Манжийг эсэргүүцсэн бослого тэмцлийн ямар хэлбэрээр эхэлсэн бэ? /1 оноо/  
A. Дугуйлангийн хөдөлгөөн байгуулан тэмцэх  
B. Хятадын мөнгө хүүлэгч пүүсүүдийг хөөх  
C. Манжийн цэрэгтэй шууд тулгаран тулалдах  
D. Манжийн албуудыг хаяж босох  
E. Сайн эрсийн тэмцлээр

33. Өвөр Монголын тайж Цогдалайн удирдсан зэвсэгт бослого ямар зорилготой байсан бэ? /2 оноо/  
A. Өртөө харуулыг довтлон цохих  
B. Бэлчээр нутгаа хамгаалах  
C. Өрийн дансыг шатаах  
D. Мөнгө хүүлэгч Хятад пүүсүүдийг хөөх  
E. Хятад худалдаачдын хөрөнгийг хураах

34.

34. Манжийн эрхшээлийн үеийн Халхын зарим аймгийг газарзүйн байршлаар нь баруунаас зүүн рүү зөв эрэмбэлнэ үү /1 оноо/

1. Түшээт хан аймаг 2. Засагт хан аймаг 3. Сэцэн хан аймаг

A. 3,1,2

B. 1,2,3

C. 1,3,2

D. 2,1,3

E. 2,3,1

35.

35. Шинэ засгийн бодлогын гол зорилго юу байв?

/1 оноо/

A. Монгол нутагт тариа тарих

B. Монголыг Хятадчилах, уусгах

C. Зах хязгаар нутгуудад хот сууринг байгуулах

D. Монголын бурхны шашныг тэтгэх

E. Монгол нутгаас байгалийн баялаг олзворлох

36.

36. Манжийн төрөөс хэрэгжүүлсэн “Шинэ засгийн бодлого”-ын соёлын хүрээнд үзүүлэх үр дагаврыг Монголчууд юу гэж үзэж байв? /2 оноо/

A. Хятад биш үндэстнийг хүчээр Хятадад уусган устгах

B. Монголыг Хятадчилах бодлого

C. Малын бэлчээрийг тариалангийн талбай болгох бодлого

D. Хэл, шашныг устгах бодлого

E. Хятадтай адил болгох бодлого

37.

37. 1911 оны хувьсгалын дараа Их хүрээг хэрхэн нэрлэсэн бэ?

/1 оноо/

A. Улаанбаатар

C. Да хүрээ

D. Богдын хүрээ

E. Хүрээ

38.

38. “1911 оны 12-р сарын 29-ний өдрийг яг ёслол болсон цаг мөчид, Монголын өнцөг булан бүрт хүмүүс хүрээний зүг хандаж, нэгэн зэрэг сөгдөн мөргөж, зул, хүж өргөн баясчээ. Үүнийг үзсэн гадаадынхан олон Монголчуудын нүд урьд өмнө хэзээ ч ингэж гэрэлтэж байсныг хараагүй хэмээн бичсэн байдаг” Дээрх түүхэн үйл явдал ямар утга санаа илэрхийлж байна вэ?

/2 оноо/

- A. хүндлэл
- B. Ёс заншил, өв уламжлалаа хүндэтгэх үйл хэрэг
- C. Өвөг дээдсээ хүндэтгэх ёсыг бэхжүүлэх үйл хэрэг
- D. Шашин шүтлэг, өв соёлоо хүндэтгэх үйл хэрэг
- E. Үндэсний сэргэн мандалтын бодит үр дүн, үйл хэрэг

39.

39. Д.Бодоогийн байгуулсан улс төрийн бүлгэмийг сонгоно уу /1 оноо/

- A. Ноёдын бүлгэм
- B. Зүүн хүрээний бүлгэм
- C. Угсаатан хэргэмтний бүлгэм
- D. Консулын дэнжийн бүлгэм
- E. Ногоонтны бүлгэм

40.

40. 1921 онд ардын засгийн газрын эрх шилжүүлэх ёслолыг хэзээ хийсэн бэ? /1 оноо/

- A. 1921.VII.1-3
- B. 1921.VII.13
- C. 1921.VII.12
- D. 1921.III.13
- E. 1921.VII.10

41.

41. “Азийн морин дивиз”-ийн захирагч барон Унгерны үйл ажиллагааны үр дүнг зөв тодорхойлсоныг олно уу /2 оноо/

- A. Нийслэл Хүрээг Хятад цэргээс чөлөөлсөн
- B. Ардын хувьсгалыг ялалтанд хүргэсэн
- C. Гамин цэргийг Хүрээнээс хөөн гаргасан
- D. Богд хааныг гэрийн хорионоос чөлөөлсөн
- E. Монголд хэмжээгүй эрхт хаант засаглалыг сэргээсэн

42. 1921 оны хувьсгалын үр дүнд нийгмийн хүрээнд гарсан дэвшил аль вэ? /1 оноо/  
A. Хамжлагат харилцааг халж, бусдын хөдөлмөрийг мөлжих явдал зогсов  
B. Монгол улс хэмжээт эрхт хаант засагт шилжив  
C. Бага, дунд сургуулийн танхимын дүрмийг батлав  
D. “Засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм”-ийг батлав  
E. Үндэсний мөнгөн тэмдэгттэй болох эхлэл тавигдав
43. 1921 оны хувьсгалын ач холбогдлыг оновчтой тодорхойлсоныг олно уу /2 оноо/  
A. Монгол улс тусгаар тогтнолоо дахин олж сэргээсэн  
B. Манж Чин улсаас салж тусгаар тогтнолоо сэргээсэн  
C. Шинэ засгийн бодлогыг таслан зогсоосон  
D. Ар, Өвөр Монголчуудаа нэгтгэсэн  
E. Хятадын ДИУ-тай найрамдалт харилцаа тогтоосон
44. Монгол улс бүгд найрамдах засаглалд хэзээ шилжсэн бэ? /1 оноо/  
A. 1911.XII.29 B. 1921.VII.10 C. 1924.VII.10 D. 1924.XI.26 E. 1921.VII.1-3
45. Анхдугаар Үндсэн хуулиар хэний улс төрийн эрхийг хассан бэ? /1 оноо/  
A. Жирийн малчид  
B. Жинхэнэ ардууд  
C. Үгээгүй ядуу ардууд  
D. Хутагт, хувилгаад  
E. Чинээлэг иргэд
46. БНМАУ хэдэн оноос кирилл бичигт шилжсэн бэ? /1 оноо/  
A. 1924 оноос B. 1959 оноос C. 1941 оноос D. 1932 оноос E. 1937 оноос

47.

47. 1937 онд хэний удирдлагаар, ямар байгууллага гэм зэмгүй хүмүүсийг хэлмэгдүүлсэн бэ?

/2 оноо/

- A. Х.Чойбалсан “Дотоодыг хамгаалах газар”
- B. Х.Чойбалсан “Бүрэн эрхт комисс”
- C. Х.Чойбалсан, “Онцгой бүрэн эрхт комисс”
- D. Х.Чойбалсан “Дотоод явдлын яам”
- E. Х.Чойбалсан “Хөрөнгө хураах комисс”

48.

48. БНМАУ-ын ерөнхий сайд асан П.Гэндэн ЗХУ-д цөллөгт байхдаа 1937 онд БНМАУ-ын ерөнхий сайд

А.Амарт илгээсэн захидлаас:

*“...Миний бие Монголын хөрөнгийг хулгайлан завшсан буюу санаатайгаар бүрэлгэн сүйтгэсэн зүйл үгүй... Үндэсний тусгаар тогтносон байдлыг устгахаар гадаад, дотоодын харгис нартай ам ба бичгээр сүлбэлдсэн зүйл үгүй ... урьд ч үгүй, үүнээс хойш гарахгүйг ч би ойлгоно”* гэсэн баримтад ямар үйл явдлын тухай өгүүлж байгааг тогтооно уу?

/2

оноо/

- A. БНМАУ-ын хөгжлийн чиг шугамыг эсэргүүцэгчдийг таслан шийтгэж байсан тухай
- B. Улс орны тусгаар тогтнолд аюул, занал учруулсан бүлэг этгээдүүдийг илрүүлсэн тухай
- C. ЗХУ, Монголыг хувьсгалын эсэргүү нараас хамгаалж байсан тухай
- D. Улс төрийн зүтгэлтнүүдийг хилс хэрэгт гүтгэж, хэлмэгдүүлж байсан тухай
- E. Хувьсгалын эсэргүү бүлгийн удирдагчдийн өгсөн мэдүүлгийн тухай

49.

49. Дэлхийн II дайны дараа БНМАУ-ын гадаад харилцаанд ямар эерэг үр дагавар гарсан бэ?

/1 оноо/

- A. Баруун Европын орнуудтай шинжлэх ухааны бүхий л салбарт хамтран ажиллах болсон
- B. АНУ-тай хүний эрх, эрх чөлөөг түгээн дэлгэрүүлэх тал дээр хамтран ажиллаж эхэлсэн
- C. Капиталист орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлсэн
- D. Их Британи улстай цэрэг арми, соёл, шинжлэх ухааны бүхий л салбарт хамтран ажиллах болсон
- E. Монгол улсын бие даасан байдлыг дэлхийн их гүрнүүд хүлээн зөвшөөрсөн

50.

50. Аугаа эх орны дайны жилүүдэд БНМАУ хууль эрх зүйн ямар үндэслэлээр ЗХУ-ын талд зогссон бэ?

/2 оноо/

- A. 1936 оны “Үл довтлолцох гэрээ”-нд заасан үүргийн дагуу
- B. 1921 оны “Монгол-Оросын найрамдлын гэрээ”-нд заасан үүргийн дагуу
- C. 1936 оны “Харилцан туслалцах гэрээ”-нд заасан үүргийн дагуу
- D. 1939 оны “Эв найрамдлын гэрээ”-нд заасан үүргийн дагуу
- E. 1939 оны “Үл довтлолцох гэрээ”-нд заасан үүргийн дагуу

51.

51. МоАХ /Монголын ардчилсан холбоо/ - ны хэзээ байгуулагдсан бэ?

/1 оноо/

- A. 1989 оны 12-р сарын 17-нд
- B. 1990 оны 3-р сарын 7-нд
- C. 1990 оны 3-р сарын 9-нд
- D. 1990 оны 3-р сарын 12-нд
- E. 1989 оны 12-р сарын 9-нд

52.

52. “Аз болж хонх дуугарлаа, арай ядан нойрноос сэрлээ” дууны шүлгийн мөрүүд нийгмийн аль үеийг төлөөлж байна вэ? /2 оноо/

*“Хонхны дуу”*

*“Урт гар намайг зовооно  
Хэлэх үгийг минь боогдуулж  
Харах нүдийг минь халхална  
Аз болж хонх дуугарлаа  
Арай ядан нойрноос сэрлээ”*

- A. 1990 оны хувьсгалын өмнөх үе      B. 1990 оны хувьсгалын үе  
C. 1990 оны хувьсгалын дараах үе      D. 1921 оны хувьсгалын өмнөх үе  
E. 1921 оны хувьсгалын дараах үе

53.

53. МоАХ /Монголын ардчилсан холбоо/ -ны анхны ерөнхий зохицуулагч хэн бэ? /1 оноо/

- A. Д.Баасан    B. Э.Бат-Үүл      C. Ц.Элбэгдорж      D. С.Зориг      E. Ж.Батмөнх

54.

54. 1990 оны “Ардчилсан хувьсгал”-ын үр дүнд нийгмийн амьдралын хүрээнд гарсан өөрчлөлт аль вэ? /2 оноо/

- A. Олон намын тогтолцоонд шилжсэн  
B. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө баталгаажсан  
C. 1992 онд анхны чөлөөт, шударга, ардчилсан сонгууль явагдсан  
D. Өмчийн бүх хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрсөн  
E. 2015 онд хүн амын тоо 3 саяд хүрсэн

55.

55. 2014 онд Монгол улсын гадаад харилцаанд болсон онцлох үйл явдал аль нь вэ?

/1 оноо/

A. НҮБ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннан айлчлав

B. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчлав

C. Японы ерөнхий сайд Т.Кайфу айлчлав

D. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчлав

E. Гадаад бодлогын үзэл баримтлал батлагдав

56.

56. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “Гуравдагч хөрш” улс аль нь вэ?

/1 оноо/

A. Энэтхэг

B. Франц

C. Их Британи

D. Итали

E. Грек

2.1.

2.1. **Эртний улсуудын түүхэнд холбогдох соёлын дурсгалуудыг зөв харгалзуулна уу**  
/6 оноо/

- |                               |          |
|-------------------------------|----------|
| a. Руни бичиг                 | 1.Жужан  |
| b. Хар балгас                 | 2.Сяньби |
| c. Их бага бичиг              | 3.Хүннү  |
| d. Төр шашныг хослон барих ёс | 4.Түрэг  |
| e. Бөө мөргөл                 | 5.Уйгар  |
| f. Эмээлийн төмөр дөрөө       | 6.Хятан  |

2.2.

2.2. **Монголын Юань улсын түүхэнд холбогдох үйл явдлыг он цагтай нь зөв харгалзуулна уу**  
/6 оноо/

- |   |                |
|---|----------------|
| a. Юань улс унаж, Хятад дахь Монголын ноёрхол эцэс болов.       | 1. 1264 он     |
| b. Төвөдийн Пагва ламыг залж хоёр ёсны зарчимыг хэрэгжүүлэв     | 2. 1271 он     |
| c. Улсын нэрийг Да Юань буюу Их Юань хэмээн өөрчлөв             | 3. 1260 он     |
| d. Олон жил дараалан ган зуд нүүрлэн улсын эдийн засаг доройтов | 4. 1269 он     |
| e. Хубилай хаан нийслэлээ өнөөгийн Бээжинд нүүлгэн шилжүүлэв    | 5. 1300-аад он |
| f. Хубилай хаан Пагва ламаар дөрвөлжин бичгийг зохиолгов        | 6. 1368 он     |

2.3.

2.3. 1911-1918 онд холбогдох түүхэн үйл явдлын он цагийг тохируулахдаа 1-8 хүртэлх өгөгдлөөс сонгож харгалзуулна уу. /2 өгөгдөл илүү байгааг анхаарна уу/

- /6 оноо/
- |  |            |
|--|------------|
| a. Т.Намнансүрэн анхны ерөнхий сайд болов                          | 1. 1911 он |
| b. Үндэсний банк байгуулах эхлэл тавигдав                          | 2. 1912 он |
| c. “Нийслэл сонин бичиг” сэтгүүл гарав                             | 3. 1913 он |
| d. “Шинэ толь” сэтгүүл хэвлэгдэх болов                             | 4. 1914 он |
| e. Богд Жавзандамба шашин, төрийг хослон баригч хаанд өргөмжлөгдөв | 5. 1915 он |
| f. Дээд, доод танхим бүхий улсын их хурал байгуулагдав             | 6. 1916 он |
|  | 7. 1917 он |
|  | 8. 1918 он |

2.4.

2.4. Түүхэн үйл явдлын он цагийг зөв тогтооно уу.

- /6 оноо/
- |  |            |
|--|------------|
| a. 1240 онд зохиогдсон “Монголын нууц товчоо”-ны 800 жилийн ой хэзээ болох вэ? | 1. 2050 он |
| b. Монголын түүхийн 5 боть хэзээ хэвлэгдсэн бэ?                                | 2. 2040 он |
| c. Монгол улс хэдэн онд Бээжингийн олимпоос гурван алтан медаль хүртсэн бэ?    | 3. 1991 он |
| d. 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн 50 жилийн ой хэзээ болох вэ?        | 4. 2008 он |
| e. 1990 оны ардчилсан хувьсгалын 60 жилийн ой хэзээ болох вэ?                  | 5. 2042 он |
| f. Монгол бичгээ сэргээж хос бичигтэн болгох ажил хэзээ бэ?                    | 6. 2003 он |

өрнөсөн

№	D ХУВИЛБАР	
	Зөв хариу	Оноо
1	D	1
2	C	1
3	E	1
4	C	1
5	B	1
6	D	2
7	B	1
8	E	2
9	D	1
10	A	2
11	D	2
12	C	1
13	B	2
14	D	1
15	E	1
16	D	2
17	C	1
18	B	1
19	D	2
20	B	2
21	D	1
22	A	1
23	D	1
24	A	1
25	D	1
26	C	2
27	B	1
28	C	2
29	B	1
30	D	1

31	E	1
32	D	1
33	B	2
34	D	1
35	B	1
36	D	2
37	B	1
38	E	2
39	D	1
40	E	1
41	A	2
42	A	1
43	A	2
44	D	1
45	D	1
46	C	1
47	C	2
48	D	2
49	E	1
50	C	2
51	E	1
52	B	2
53	D	1
54	E	2
55	D	1
56	A	1

2.1	A=4, B=5, C=6, D=1, E=3, F=2	6
2.2	A=6, B=3, C=2, D=5, E=1, F=4	6
2.3	A=2, B=6, C=5, D=3, E=1, F=4	6
2.4	A=2, B=6, C=4, D=5, E=1, F=3	6